

ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ЖУРАМ

Нэг. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1. Энэхүү журмын зорилго нь Монгол улсын "Үнэт цаасны зах зээлийн тухай", "Компанийн тухай" хуулийн дагуу үнэт цаасаа олон нийтэд санал болгон гаргах шийдвэр гаргаж, төрийн зохицуулах байгууллагаас зөвшөөрөл авсан үнэт цаас гаргагчийг болон түүний гаргасан үнэт цаасыг "Монголын Хөрөнгийн бирж" ХК /цаашид МХБ гэх/-д бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлээс хасах болон бүртгэлийн үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.
2. МХБ нь үнэт цаас гаргагч болон түүний үнэт цаасыг бүртгэхдээ энэхүү журмаар тогтоосон бичиг баримтын бүрдэл, бүртгэлийн шалгуур хангасан эсэхийг хянаж, шаардлага хангасан үнэт цаасыг бүртгэнэ. Зөвхөн бүртгэгдсэн үнэт цаасыг олон нийтэд арилжина.
3. Хүсэлт гаргагч нь бүртгүүлэх баримт бичгийг Монгол хэл дээр үйлдэнэ. Баримт бичгийн эх хувь нь гадаад хэл дээр үйлдэгдсэн бол албан ёсны Монгол орчуулгын хамт ирүүлнэ.
4. Журамд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг МХБ-ийн Төлөөлөн удирдах зөвлөл /цаашид ТУЗ гэх/ шийдвэрлэнэ.
5. Журмын нэр томъёог дараах байдлаар ойлгоно. Үүнд:
 - **“ Үнэт цаас гаргагч ”** - Үнэт цаас гаргаж, олон нийтэд санал болгох зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос /цаашид СЗХ гэх / авсан “ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль ”-ийн 4 дүгээр зүйлд заасан этгээд;
 - **“ Үнэт цаас ”** - “ Үнэт цаасны зах зээлийн тухай хууль ”-д заасан үнэт цаас гаргагчийн хувьцаа, өрийн бичиг;
 - **“ Үнэт цаас гаргагчийн бүртгэл ”** – Үнэт цаас гаргагчийг МХБ-ийн бүртгэлтэй компанийн жагсаалтанд бүртгэн авах үйл ажиллагаа;
 - **“ Үнэт цаасны бүртгэл ”** – Үнэт цаасыг МХБ-ийн бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтанд бүртгэн авах үйл ажиллагаа;
 - **“Бүртгэлтэй үнэт цаасны жагсаалт ”** – Бүртгэлийн шалгуур хангаж, үнэт цаас арилжих зөвшөөрөл авсан үнэт цаасны жагсаалт;
 - **“ Бүртгэлтэй компанийн жагсаалт ”** – МХБ-д бүртгэгдсэн боловч үнэт цаасаа олон нийтэд санал болгож арилжаагүй буюу бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтаас түр хасагдсан үнэт цаас гаргагчийн жагсаалт;

- “**Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах**” - Эрх бүхий этгээдийн шийдвэрээр үнэт цаас гаргагчийн зохион байгуулалтын хэлбэр, үнэт цаасны нэр, нэрлэсэн үнэ, тоо ширхэгт орсон өөрчлөлт, бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтаас түр хасагдсан үнэт цаасыг дахин бүртгэж авах үйл ажиллагаа;
- “**Үнэт цаасны бүртгэлээс хасах**” – Үнэт цаасыг бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтаас түр болон бүрмөсөн хасах үйл ажиллагаа;
- “**Түйцэтгэх захирал**” - МХБ-ийн Гүйцэтгэх захирал;
- “**Үнэт цаас арилжих зөвшөөрөл**” - Үнэт цаасыг үнэт цаасны арилжаагаар олон нийтэд арилжих тухай МХБ-ийн зөвшөөрөл;

Хоёр. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БҮРТГЭЛ

6. "Компанийн тухай", "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн дагуу нийтэд санал болгохоор үнэт цаас гаргаж, СЗХ-оос зөвшөөрөл авсан этгээд МХБ-д бүртгүүлэх хүсэлт гаргаж болно.
7. Хүсэлт гаргахдаа баримт бичгийг бүрдүүлэн ирүүлэх бөгөөд тэдгээрийг хуудас бүрээр дугаарлаж, хавтаслан, нийт хуудасны тоог хүсэлтэд тэмдэглэсэн байна. Үүнд:
 - 7.1 МХБ-д үнэт цаас гаргагчийг бүртгүүлэх хүсэлт;
 - 7.2 Үнэт цаас гаргах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;
 - 7.3 СЗХ-ны тогтоол;
 - 7.4 СЗХ-ны “Нийтэд санал болгон гаргах үнэт цаасыг бүртгэх тухай журам”-ын дагуу бэлтгэсэн үнэт цаас гаргагчийн болон үнэт цаасны танилцуулга / танилцуулгад компани нь охин компани болон салбар, төлөөлөгчийн газартай бол түүний талаархи мэдээллийг тусгасан байна /;
 - 7.5 Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар;
 - 7.6 Улсын бүртгэлд бүртгэгдсэн дүрмийн хуулбар;
 - 7.7 Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний баталгаажуулсан хуулбар;
 - 7.8 Үнэт цаас гаргах болон үнэт цаас гаргагчийн эрхлэх үйл ажиллагааны хувьд тусгай зөвшөөрөл шаардлагатай бол эрх бүхий этгээдээс олгосон зөвшөөрөл;
 - 7.9 Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5-аас дээш хувийг эзэмшиж байгаа этгээдийн талаархи мэдээлэл;
 - 7.10 Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан нь уг компанийн болон бусад компанийн үнэт цаасыг эзэмшдэг бол түүний хувь, хэмжээ;
 - 7.11 Аудитийн байгууллагаар баталгаажуулсан сүүлийн 3 жилийн санхүүгийн тайлан тэнцлийг тодруулгын хамт аудиторын тайлан, дүгнэлт, аудиторын танилцуулгын хамт / Охин болон салбар, төлөөлөгчийн газартай компанийн хувьд нэгдсэн тайлан, хараат компанийн хувьд толгой компанийн тайланг тус тус ирүүлнэ /;
 - 7.12 Төсөл хэрэгжүүлэх зорилгоор хувьцааны захиалга авах замаар шинээр ХК байгуулж байгаа бол эхлэлтийн тайлан баланс;
 - 7.13 Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийсэн байгууллагын тайлан, үнэлгээний байгууллагын танилцуулга;
 - 7.14 Үнэт цаас гаргагчаас бусадтай байгуулсан их хэмжээний гэрээ хэлцэл, өр, зээл, барьцаа, баталгаа гаргасан бол тодорхойлолт, баримт, материалын хуулбар;

- 7.15 Үнэт цаас гаргагчийн болон салбар, төлөөлөгчийн газрын эрх бүхий албан тушаалтан, үнэт цаас хариуцсан ажилтны анкет;
- 7.16 Журмын 72 -д заасан үнэт цаасны элсэлтийн хураамж төлсөн баримт;
8. Компанийн бүртгэл хариуцсан мэрэгжилтэн үнэт цаас гаргагчаас ирүүлсэн хүсэлт, энэ журмаар тогтоосон бичиг баримтыг бүрэн хүлээн авсан өдрөөс хойш ажлын 7 хоногийн дотор хянан, танилцуулга бэлтгэнэ.
9. Танилцуулга, баримт бичгийг үндэслэн үнэт цаас гаргагчийг бүртгэлтэй компанийн жагсаалтанд бүртгэх тухай шийдвэрийг Гүйцэтгэх захирал гаргаж, үнэт цаас гаргагчид мэдэгдэл хүргүүлнэ.
10. Хувьцаат компани /цаашид ХК гэх/ -ийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулагдаж байгаа 100 хувь төрийн өмчит хуулийн этгээдийг эрх бүхий этгээдийн шийдвэрийн дагуу бүртгэлтэй компанийн жагсаалтанд шууд бүртгэн авна.
11. Гүйцэтгэх захирлын шийдвэрийн дагуу компанийн бүртгэл хариуцсан мэрэгжилтэн үнэт цаас гаргагчийг бүртгэлтэй компанийн жагсаалтанд бүртгэж, судалгаанд хамруулна.
12. Бүртгэлтэй компанийн жагсаалтанд бүртгэгдсэн үнэт цаас гаргагч нь үнэт цаас арилжих зөвшөөрөл авсан тохиолдолд хариуцсан мэрэгжилтний мэдэгдлийн дагуу бүртгэлтэй үнэт цаасны бүртгэлд шилжүүлэн бүртгэнэ.
13. Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй компанийн жагсаалтанд бүртгэгдсэн өдрөөс хойш 1 жилийн дотор үнэт цаасаа олон нийтэд санал болгож арилжаагүй бол түүнийг Гүйцэтгэх захирлын шийдвэрээр бүртгэлтэй компанийн жагсаалтаас хасаж, мэдэгдэл хүргүүлнэ. / Энэ заалт нь төрийн өмчийг хувьчлах замаар байгуулагдсан үнэт цаас гаргагчид хамаарахгүй. /
14. Бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтаас түр хасагдсан үнэт цаас гаргагчийг 2 жил хүртэл хугацаагаар бүртгэлтэй компанийн жагсаалтанд бүртгэж, үнэт цаасыг нь тусгай хуваарийн дагуу арилжиж болно.
15. Журмын 14-д заасан хугацаанд бүртгэлийн шалгуур, шаардлагыг хангаагүй бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтаас түр хасагдсан үнэт цаас гаргагчийг Гүйцэтгэх захирлын шийдвэрээр МХБ-ийн бүртгэлтэй компанийн жагсаалтаас хасаж, Хороонд мэдэгдэн, үнэт цаасыг хадгаламжаас хасах мэдэгдлийг ҮЦГТТХТ –д хүргүүлнэ.

Гурав. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛ

16. Үнэт цаас гаргагч нь МХБ-д бүртгүүлснээс хойш 1 жилийн дотор хувьцаа арилжих зөвшөөрөл хүсэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

- 16.1 Хувьцаа бүртгүүлэхийг хүссэн албан бичиг;
- 16.2 Хувьцаа бүртгүүлэх өргөдөл / хавсралт №1 /;
- 16.3 Хувьцааны нэрлэсэн үнэ, худалдахаар санал болгосон үнийг тогтоосон үндэслэл, тооцоо, үнийг тогтоосон эрх бүхий этгээдийн шийдвэр;
- 16.4 ХК байгуулахад анхдагч зах зээлд хувьцааны захиалга авах замаар хувьцаа худалдсан бол эзэмшсэн этгээдийн төлбөр хийснийг нотлох баримтын хуулбар;
- 16.5 Хувьцааг анхдагч зах зээлд борлуулахад зуучлах мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулсан бол гэрээний хуулбар, зуучлагчийн талаархи мэдээлэл, зуучлагчаар дамжуулан зах зээлд нийлүүлэх хувьцааны захиалга / нийлүүлэх хувьцааны тоо ширхэг, үнэ, арилжааны программд нийлүүлэлт хийх өдөр/;
- 16.6 Хэрэв хувьцааг анхдагч зах зээлд зуучлагчаар дамжуулахгүй өөрөө худалдах бол мэдээллийг олон нийтэд хүргэх, сурталчлах марктенгийн төлөвлөгөө, зарласан хувьцаанаас анхдагч зах зээлд гаргах хувьцааны захиалга буюу албан бичиг / нийлүүлэх хувьцааны тоо ширхэг, үнэ, нийлүүлэлт хийх хугацаа/;
- 16.7 Анхдагч зах зээлд хувьцааг оюуны өмчийг үнэлэх хэлбэрээр буюу нэр зааж эзэмшүүлсэн бол үндэслэл, үнэлгээний байгууллагын болон төлбөр хийснийг батлах аудитын байгууллагын дүгнэлт;
- 16.8 Сүүлийн жилийн санхүүгийн тайлан;
- 16.9 МХБ-д бүртгүүлэхэд ирүүлсэн материалд өөрчлөлт орсон бол тухайн өөрчлөлттэй холбоотой баримт бичиг;
- 16.10 Бүртгэлтэй компанийн жагсаалтанд бүртгэгдсэнээс хойш 1 жил өнгөрсөн үнэт цаас гаргагч нь журмын 73-д заасан бүртгэлтэй компанийн жилийн хураамж төлсөн баримт;

17. Засгийн газар, аймаг, нийслэлийн засаг даргаас гаргасан өрийн бичиг / цаашид орон нутгийн өрийн бичиг гэх /- ийг бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

- 17.1 Засгийн газрын өрийн бичгийг бүртгүүлэхэд Сангийн сайдын тушаал, орон нутгийн өрийн бичгийг бүртгүүлэхэд холбогдох ИТХ-ын шийдвэр;
- 17.2 Өрийн бичиг бүртгүүлэхийг хүссэн албан бичиг;
- 17.3 Өрийн бичиг бүртгүүлэх өргөдөл / хавсралт № 2 /;
- 17.4 Өрийн бичгийг зах зээлд нийлүүлэх захиалга / Тоо ширхэг, үнийн дүн, нэгжийн үнэ, хүүгийн хэмжээ, хүү болон үндсэн төлбөр хийх хугацаа /;
- 17.5 Орон нутгийн өрийн бичгийг бүртгэхэд түүний төлбөрийн найдвартай байдлыг хангахтай холбоотой барьцаа баталгааны баримт;

18. Компанийн өрийн бичиг бүртгүүлэх хүсэлт гаргагч нь журмын 7-д заасан материалын хамт дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

- 18.1 Өрийн бичиг бүртгүүлэхийг хүссэн албан бичиг;
- 18.2 Өрийн бичиг бүртгүүлэх өргөдөл / хавсралт №3 /;
- 18.3 Өрийн бичгийг зах зээлд нийлүүлэх захиалга / Тоо ширхэг, үнийн дүн, нэгжийн үнэ, хүүгийн хэмжээ, хүү болон үндсэн төлбөр хийх хугацаа /;

- 18.4 Өрийн бичгийн төлбөрийн найдвартай байдлыг хангахтай холбоотой барьцаа баталгааны баримт;
19. Нэмж гаргасан үнэт цаасыг бүртгүүлэхэд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:
- 19.1 Нэмж гаргасан үнэт цаас бүртгүүлэх хүсэлт;
 - 19.2 Нэмж гаргасан үнэт цаас бүртгүүлэх өргөдөл / хавсралт /;
 - 19.3 Нэмж гаргасан хувьцааг бүртгүүлэхэд “Компанийн тухай хууль”-ийн 39-д заасан хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаархи баримт, материал;
 - 19.4 Хэрэв компанийн хувь нийлүүлэгчдийн хурлаас нэмж гаргасан хувьцааг хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжинд эзэмшүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн бол түүний үндэслэл, тайлбар;
 - 19.5 Компанийн бонд нэмж бүртгүүлэхэд олон нийтэд арилжигдсан бондын үндсэн, болон хүүгийн төлбөр төлөлтийн тайлан, төлбөр тооцооны байгууллагын тодорхойлолт;
 - 19.6 Журмын 72-д заасан үнэт цаасны элсэлтийн хураамж төлсөн баримт;
20. Өрийг хувьцаагаар солиход дараах баримт бичгийг бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:
- 20.1 Өрийг хувьцаагаар солих тухай хувь нийлүүлэгчдийн хурлын шийдвэр;
 - 20.2 Өрийг хувьцаагаар солих төсөл / гаргах хувьцааны хэмжээ, үнэ, зорилго, хэрэгжүүлэх нөхцөл, журам, компанийн дүрэм болон бусад баримт бичигт оруулах өөрчлөлт гэх мэт/;
 - 20.3 “Компанийн тухай хууль”-ийн 25.6-д заасан хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэхээр авсан арга хэмжээ;
 - 20.4 Зээлдүүлэгч, харилцагч нь өрийг хувьцаагаар сольж авч байгаа тохиолдолд тэдгээрийн зөвшөөрөл;
 - 20.5 Өр үүссэнийг батлах анхан шатны баримт;
 - 20.6 Журмын 72-д заасан үнэт цаасны элсэлтийн хураамж төлсөн баримт;

Дөрөв. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ШАЛГУУР

21. Үнэт цаасыг бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтанд бүртгэн авахад бүртгэлийн ерөнхий болон тусгай шалгуурыг хэрэглэх бөгөөд зөвхөн шалгуур хангасан үнэт цаасанд арилжих зөвшөөрөл олгоно.
22. Улс орны эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэдэг дэд бүтцийн болон стратегийн чухал ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа эрхэлдэг ХК-ийн үнэт цаасыг бүртгэлийн тусгай шалгуураар бүртгэнэ.
23. Дараах шалгуурыг хангасан хувьцааг бүртгэлийн ерөнхий шалгуур хангасан үнэт цаас гэж үзнэ. Үүнд:

- 23.1 Компанийн хувь нийлүүлэгчдийн хөрөнгө 10.0 сая төгрөгөөс дээш байна.
- 23.2 Бүртгүүлэх үнэт цаасны үнийн дүнгийн 10-аас доошгүй хувийг эргэлтийн бус хөрөнгийн дүн бүрдүүлсэн байна.
- 23.3 Бүртгүүлэх үеийн хувьцаа худалдан авах захиалагчийн тоо нь 50-иас цөөнгүй байх ба түүний 50-иас доошгүй хувь нь “Компанийн тухай хууль”-ийн 13.5-д заасан нөхцлийг хангах хэмжээний төлбөрийг ҮЦТТХТ дэхь нэрийн дансандаа захиалсан хувьцааг бүрэн худалдан авах хүртэл буцаан олгохгүй нөхцөлтэйгээр байршуулсан юмуу компанид урьдчилан оруулсныг нотлох баримтыг бүрдүүлсэн байна.
- 23.4 Нийт энгийн хувьцааны 30-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгож арилжина.
- 23.5 Компани нь аж ахуйн үйл ажиллагааг 1-ээс доошгүй жил эрхлэн явуулсан байна.
- 23.6 Үнэт цаас гаргагч нь ашигтай ажилласан байх ба хэрэв алдагдалтай ажилласан бол уг алдагдлын хэмжээ нь өөрийн хөрөнгийн 30 хувиас илүүгүй байна.
- 23.7 Төрийн өмчийг хувьчлах зорилгоор байгуулагдсан 100 хувь төрийн өмчит ХК-д 23.3; 23.4; 23.6 заалт, төсөл хэрэгжүүлэх зорилгоор хувьцааны захиалга авах аргаар байгуулагдсан ХК-д 23.5; 23.6 заалт хамаарахгүй.

24. Дараах шалгуурыг хангасан өрийн бичгийг бүртгэлийн ерөнхий шалгуур хангасан үнэт цаас гэж үзнэ. Үүнд:

- 24.1 Хувь нийлүүлэгчдийн хөрөнгө 10.0 сая төгрөгөөс дээш байна.
- 24.2 Үл хөдлөх хөрөнгийн дүн нь нийт хөрөнгийн үнийн дүнгийн 20-иос доошгүй хувийг бүрдүүлсэн байна.
- 24.3 Бүртгүүлэх үнэт цаасны тоо ширхэг 50.0 мянган ширхгээс, үнийн дүн 500.0 сая төгрөгөөс дээш байна.
- 24.4 Компани нь аж ахуйн үйл ажиллагааг 3-аас доошгүй жил тасралтгүй эрхэлж, сүүлийн жилд ашигтай ажилласан байна.
- 24.5 Нийтэд санал болгон гаргасан өрийн бичгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг гуравдагч этгээдийн баталгаа, өөрийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн барьцаагаар баталгаажуулсан байна. Энэ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагаар зээлжих эрхийн үнэлгээ хийлгэсэн өрийн бичиг гаргагчид хамаарахгүй

25. Дараах шалгуурыг хангасан хувьцааг бүртгэлийн тусгай шалгуур хангасан үнэт цаас гэж үзнэ. Үүнд:

- 25.1 Хувь нийлүүлэгчдийн хөрөнгө 10.0 сая төгрөгөөс дээш байна.
- 25.2 Бүртгүүлэх үнэт цаасны үнийн дүнгийн 20-иос доошгүй хувийг эргэлтийн бус хөрөнгийн дүн бүрдүүлсэн байна.
- 25.3 Бүртгүүлэх үеийн хувьцаа худалдан авах захиалагчийн тоо нь 50-иас цөөнгүй байх ба түүний 50 -иас доошгүй хувь нь “Компанийн тухай хууль”-ийн 13.5-д заасан нөхцлийг хангах хэмжээний төлбөрийг ҮЦТТХТ дэхь нэрийн дансанд захиалсан хувьцааг бүрэн худалдан авах хүртэл буцаан олгохгүй нөхцөлтэйгээр байршуулсан юмуу компанид урьдчилан оруулсныг нотлох баримтыг бүрдүүлсэн байна.
- 25.4 Нийт энгийн хувьцааны 10-аас доошгүй хувийг олон нийтэд санал болгож арилжина.
- 25.5 Компани нь 3-аас доошгүй жил аж ахуйн үйл ажиллагааг тасралтгүй эрхэлсэн байна.

- 25.6 Төрийн өмчийг хувьчлах зорилгоор байгуулагдсан 100 хувь төрийн өмчит ХК-ийг бүртгэхэд 25.3; 25.4 заалт, төсөл хэрэгжүүлэх зорилгоор хувьцааны захиалга авах аргаар байгуулагдсан ХК-ийг бүртгэхэд 25.5 заалт хамаарахгүй.
26. Дараах шалгуурыг хангасан өрийн бичгийг бүртгэлийн тусгай шалгуур хангасан үнэт цаас гэж үзнэ. Үүнд:
- 26.1 Хувь нийлүүлэгчдийн хөрөнгө 10.0 сая төгрөгөөс дээш байна.
 - 26.2 Нийт хөрөнгийн 30-аас доошгүй хувь нь үл хөдлөх хөрөнгө байна.
 - 26.3 Бүртгүүлэх үнэт цаасны тоо ширхэг 100.0 мянган ширхгээс, үнийн дүн нь 1.0 тэрбум төгрөгөөс дээш байна.
 - 26.4 Компани нь 5-аас доошгүй жил аж ахуйн үйл ажиллагааг тасралтгүй эрхэлсэн байна.
 - 26.5 Нийтэд санал болгон гаргасан өрийн бичгийн үндсэн болон хүүгийн төлбөрийг гуравдагч этгээдийн баталгаа эсвэл өөрийн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхийн барьцаагаар баталгаажуулсан байна. Энэ нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн үнэлгээний байгууллагаар зээлжих эрхийн үнэлгээ хийлгэсэн өрийн бичиг гаргагчид хамаарахгүй
27. Өрийн бичиг бүртгүүлэхэд тавигдах ерөнхий болон тусгай шалгуур нь Засгийн газрын болон Засгийн газар, бусад этгээдийн баталгаатай орон нутгийн өрийн бичигт хамаарахгүй.
28. Бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтад бүртгэгдсэн үнэт цаасны шалгуур үзүүлэлтийг дараа жилийн 05 дугаар сарын 01-ны дотор нэг удаа нэгдсэн байдлаар дүгнэн журмын 66.3-д заасан тогтмол шалгалтыг сард нэг удаа хийнэ.

Тав. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

29. Бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтанд бүртгэгдсэн үнэт цаас гаргагчид дараах шаардлага тавигдана. Үүнд
- 29.1 Үнэт цаас гаргагч нь Монгол улсын үнэт цаасны зах зээл дээр мөрдөгдөж буй хууль, тогтоомж, эрх бүхий этгээдийн батлан гаргасан журам, заавар, гэрээг дагаж мөрдөн, хөрөнгө оруулагч, болон эрх бүхий байгууллагын өмнө хүлээсэн үүргээ бүрэн биелүүлж ажиллана.
 - 29.2 Үнэт цаас гаргагчийн удирдлага нь компанийн бизнесийн үйл ажиллагааг үр дүнтэй удирдаж, хөрөнгө оруулагч, хамтрагч нарын эрхийн тэнцвэртэй байдлыг хангах зорилгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн аргачлал, удирдамжийн дагуу өөрийн компанийн засаглалын журам, дүрмийг батлан мөрдөж болно.
 - 29.3 Үнэт цаастай холбоотой мэдээ, мэдээллийг олон нийтэд хүргэх, хувьцаа эзэмшигч, мэрэгжлийн байгууллагын өмнө хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг бүхий үнэт цаас хариуцсан ажилтантай байна.
 - 29.4 Үнэт цаасны гүйлгээ, үнэ ханш, арилжааны хэмжээ, явцад нөлөөлөх мэдээ, компанийн болон удирдлагын үйл ажиллагааны талаар хувьцаа эзэмшигч болон МХБ-д шударга, шуурхай, ил тод хүргэнэ.
 - 29.5 Санхүүгийн тайлан балансыг олон улсын нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн үнэн зөв гаргаж, холбогдох журмын дагуу олон нийтэд мэдээлнэ.

- 29.6 Хувь нийлүүлэгчдийн хурлыг хуульд заасан хугацаанд эрх бүхий этгээдийн батлан гаргасан журам, зааврын дагуу олон нийтэд мэдээлж, хуралдуулах ба хурлаар хэлэлцэх асуудал, хурлын материал шийдвэрийг гэрээнд заасан хугацаанд МХБ-д ирүүлнэ.
- 29.7 Бүртгэлтэй нийт хувьцааны 20-иос дээш хувийг жижиг хувьцаа эзэмшигч эзэмшдэг болон “Компанийн тухай хууль”-ийн 54.1.1- 54.1.4-д заасан асуудлыг авч хэлэлцэх ХК-ийн хувь нийлүүлэгчдийн хурлын материалыг гэрээ байгуулах замаар мэрэгжлийн байгууллагаар дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэнэ.
- 29.8 Ногдол ашиг тараах тухай шийдвэр гарч, тарааж эхэлснээс хойш ажлын 10 хоногийн дотор компаниас ногдол ашгаа аваагүй хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг ҮЦТТХТ -тэй гэрээ байгуулах замаар тараана.
30. Үнэт цаас гаргагчид тавигдах шаардлагын хэрэгжилтэд энэхүү журам болон “Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээ”-ний дагуу хяналт тавьж дүгнэнэ.

Зургаа. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

31. Бүртгэлтэй компанийн жагсаалтанд бүртгэгдсэн үнэт цаас гаргагч нь үнэт цаас бүртгүүлэхэд журмын 3 дугаар бүлэгт заасан материалыг бүрдүүлэн ирүүлнэ.
32. Үнэт цаасны бүртгэл хариуцсан мэрэгжилтэн үнэт цаас гаргагчаас МХБ-д ирүүлсэн үнэт цаас бүртгүүлэх хүсэлт шаардлагатай баримт материалыг бүрэн хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор тухайн үнэт цаас нь бүртгэлийн шалгуурыг хангаж байгаа эсэхэд шалгалт хийнэ.
33. Шаардлагатай тохиолдолд мэрэгжилтэн үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж, тухайн компанийн удирдлагаас үнэт цаас, үнэт цаасаар хийх хөрөнгө оруулалттай холбоотой асуудлаар тодруулга, нэмэлт баримт гаргуулан авч болно.
34. Үнэт цаасны бүртгэлийн шалгалтын тайлан, дүгнэлтийг Захирлын зөвлөлийн хурлаар / цаашид ЗЗХ гэх / хэлэлцэн үнэт цаасыг бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтад бүртгэх эсэх тухай шийдвэрийг Гүйцэтгэх захирал гаргана.
35. Бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтад бүртгэгдсэн үнэт цаасыг арилжих зөвшөөрөл олгоно.
36. Үнэт цаас гаргагч нь үнэт цаас бүртгүүлэх хүсэлтийг МХБ-д бүртгүүлэх хүсэлттэй зэрэг гаргаж болно. Энэ тохиолдолд үнэт цаас гаргагчийг МХБ-д бүртгэх, үнэт цаасыг бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтанд бүртгэх шийдвэрийг зэрэг гаргана.
37. Гүйцэтгэх захирлын тушаалыг үндэслэн үнэт цаасны бүртгэл хариуцсан мэрэгжилтэн үнэт цаасанд код тогтоон, хувьцааг зохих салбарын ангилалд хамруулж, бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтад бүртгэн үнэт цаас гаргагчид мэдэгдэл хүргүүлнэ.

38. Үнэт цаас гаргагчийн хувьцааг үсгэн болон тоон код, үнэт цаасны нэрээр бүртгэнэ. Харин Засгийн газар, орон нутаг, компанийн гаргасан өрийн бичгийг тоон код, нэрээр бүртгэнэ.
39. Үнэт цаасыг олон нийтэд арилжихад түүний нэр, тоон кодыг хэрэглэнэ.
40. Үнэт цаасны код, нэрийг давхардуулж үл болно. Харин үнэт цаас гаргагчийн энгийн болон давуу эрхийн хувьцаа, компанийн гаргасан төрөл бүрийн нөхцөлтэй өрийн бичиг нь бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтад ижил нэрээр бүртгэгдэх боловч тоон кодоор ялгагдана.
41. Энгийн болон давуу эрхийн хувьцаа, компанийн гаргасан төрөл бүрийн нөхцөлтэй өрийн бичиг нь үнэт цаасны дэлгэрэнгүй бүртгэлд ижил нэрээр бүртгэгдэнэ.
42. Засгийн газар, орон нутаг, компанийн гаргасан өрийн бичгийг бүртгэхэд түүний нэрэнд өрийн бичгийн хугацаа, жилийн хүүгийн хэмжээ, хүү төлөгдөх хугацааг сараар илэрхийлсэн үзүүлэлтийг тусгана. / Жишээ нь ЗГБ –120-0.8-12; УБ-СБД-520-12.1-6; ДуГА-МС-1040-14.5-6, Нийслэл өргөө-120-19-3 гэх мэт/
43. Үнэт цаас гаргагчийн нэмж бүртгүүлэх энгийн хувьцаа болон бүртгэлтэй өрийн бичигтэй ижил нөхцөлтэй нэмж гаргасан өрийн бичиг нь өмнө бүртгэгдсэн үнэт цаастай адил нэр, тоон кодтой байна.
44. Хувьцааны код нь тоон болон үсгэн код гэсэн 2 хэсгээс бүрдэх бөгөөд үсгэн код нь компанийн нэрийг илэрхийлэх 3-аас доошгүй 4-өөс илүүгүй латин үсгээр тэмдэглэгдэнэ.
45. Үнэт цаасны тоон код нь 8 оронтой тооноос бүрдэх бөгөөд дараах байдалтай байна.
- 45.1 Хувьцаа – 10520000; 10520001 гэх мэт
 - 45.2 Компанийн өрийн бичиг – 23003000; 23003001 гэх мэт
 - 45.3 Засгийн газрын өрийн бичиг – 30928000; 30928001 гэх мэт байвал хамгийн сүүлийн 01 гэсэн утга нь өмнө гаргасан өрийн бичигтэй ижил нөхцөлтэй боловч хэд дэх удаагийн өрийн бичиг болохыг илэрхийлнэ/
 - 45.4 Орон нутгийн өрийн бичиг – 40101000; 42501000 гэх мэт
46. Үнэт цаасны тоон код нь дараах утгыг илэрхийлнэ. Үүнд:
- 46.1 10520000 кодны хувьд 1 -хувьцаа, 0520- үнэт цаасны код, 000- энгийн хувьцаа, / хэрэв сүүлийн 3 орон нь 001 бол давуу эрхийн хувьцаа /;

- 46.2 23003000 кодны хувьд 2- компанийн өрийн бичиг, 3003 - үнэт цаасны код, 000 – гаргасан өрийн бичгийн дугаар;
 - 46.3 30928000 кодны хувьд 3- Засгийн газрын өрийн бичиг, 0928- үнэт цаасны код, 000- гаргасан өрийн бичгийн дугаар;
 - 46.4 40101000 кодны хувьд 4- Орон нутгийн өрийн бичиг, 01- орон нутгийн харъяалал, 01 – засаг захиргааны нэгж, 000 – гаргасан өрийн бичгийн дугаар / Жишээ нь: 40101000 – Орон нутгийн өрийн бичиг, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, анхны удаа гаргасан өрийн бичиг /
- 47. МХБ нь үнэт цаас нь бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтад бүртгэгдсэн үнэт цаас гаргагчтай хавсралтаар батлагдсан " Үнэт цаас гаргагчтай байгуулах гэрээ"-ний төслийн дагуу гэрээ байгуулна. Талууд тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт заалт оруулж болно.
 - 48. Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээг үндэслэн "Үнэт цаасны төлбөр тооцоо төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК-д /цаашид ҮЦТТХТ гэх/ "Үнэт цаас хадгалах мэдэгдэл" хүргүүлнэ.
 - 49. ЗЗХ-аас үнэт цаасыг бүртгэлийн шаардлага хангаагүй гэж үзсэн нөхцөлд түүнийг бүртгэхээс татгалзаж, үнэт цаас гаргагч болон эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

Долоо. ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

- 50. Дараах тохиолдолд бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтад бүртгэгдсэн үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулна. Үүнд:
 - 50.1 Бүртгэлтэй үнэт цаас гаргагч нь “Компанийн тухай хууль”-ийн 18.1; 18.2-д заасны дагуу нэгдэх, нийлэх, хуваах замаар өөрчлөн зохион байгуулагдсан;
 - 50.2 “Компанийн тухай хууль”-ийн 52 дугаар зүйлд заасан аргаар бүртгэлтэй үнэт цаасны тоо ширхэг, нэрлэсэн үнэ өөрчлөх тухай шийдвэр гарсан;
 - 50.3 Эрх бүхий этгээдийн шийдвэрээр бүртгэлтэй үнэт цаасны нэр өөрчлөгдсөн;
 - 50.4 Гүйцэтгэх захирлын тушаалаар үнэт цаасыг бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтанд дахин бүртгэн авахад;
- 51. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт гаргахад дараах баримт бичгийг бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:
 - 51.1 Эрх бүхий этгээдийн шийдвэр;
 - 51.2 Бүртгэлд өөрчлөлт оруулах тухай үнэт цаас гаргагчийн хүсэлт;
 - 51.3 Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах асуудалтай холбоотой компанийн хувь нийлүүлэгчдийн хурлын материал, шийдвэр;
 - 51.4 Компанийг өөрчлөн байгуулж байгаа бол өөрчлөн байгуулах төсөл, арга хэлбэр, хувьцааны тоо ширхэг, нэрлэсэн үнэ өөрчлөгдөж байгаа бол шалтгаан, үндэслэл, тооцоо;
 - 51.5 Өөрчлөн байгуулалтын үр дүнд шинээр үүссэн компани тус бүрийн хаяг, байршил, оноосон нэр, өөрчлөн байгуулагдах үеийн дуусгалтын болон эхлэлтийн тайлан баланс;

- 51.6 Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийлгэсэн баримт материал;
 - 51.7 “Компанийн тухай хууль”-ийн 54 дүгээр зүйлд заасан хувьцаа эзэмшигчдийн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой шийдвэр, журам, хувьцаа эргүүлэн авах үнийг тогтоосон эрх бүхий этгээдийн дүгнэлт, үнэлгээ;
 - 51.8 ХК-ийн шинэчилсэн дүрэм;
 - 51.9 Хяналтын багцыг дангаар буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа этгээдийн эзэмшилд гарсан өөрчлөлт;
 - 51.10 Шинээр байгуулагдсан ХК-ийн эрх бүхий албан тушаалтны анкет;
52. Бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн жагсаалтаас түр хасагдсан үнэт цаас гаргагч нь энэхүү журмын дагуу дахин бүртгүүлэх хүсэлт гаргаж болно.
53. Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй компанийн жагсаалтанд бүртгэгдсэн өдрөөс хойш 1 жилийн дотор хуулиар хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг бүрэн хангаж, журмын шалгуур, шаардлагыг хангасан нөхцөлд компанийн бүртгэл хариуцсан мэрэгжилтний мэдэгдлийн дагуу албаны захирлын шийдвэрээр үнэт цаасыг бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтад дахин бүртгэнэ.
54. Хэрэв үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй компанийн жагсаалтад бүртгэгдсэн өдрөөс хойш 1 жил өнгөрсөн тохиолдолд үнэт цаас гаргагч нь дахин бүртгүүлэх хүсэлт гаргавал МХБ-д шинээр бүртгүүлэх шаардлага тавигдана.
55. Бүртгэлд өөрчлөлт оруулахад шинээр буюу дахин бүртгэгдэх үнэт цаас нь энэ журамд заасан шалгуурыг хангасан байна.
56. Үнэт цаасны бүртгэл хариуцсан мэрэгжилтэн үнэт цаас гаргагчаас ирүүлсэн бүртгэлд өөрчлөлт оруулах хүсэлт, шаардлагатай баримт материалыг бүрэн хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор бүртгэлд өөрчлөлт оруулах шалгалтын тайланг бэлтгэнэ.
57. Үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах шалгалтын тайланг үндэслэн бүртгэлд өөрчлөлт оруулах тухай шийдвэрийг Гүйцэтгэх захирал гаргаж, ҮЦТТХТ-ийн хадгаламжинд өөрчлөлт оруулах мэдэгдэл хүргүүлнэ.

Найм. ҮНЭТ ЦААСЫГ БҮРТГЭЛЭЭС ХАСАХ

58. Эрх бүхий этгээдийн шийдвэрээр үнэт цаасыг бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтаас түр буюу бүрмөсөн хасна.
59. Дараах тохиодолд үнэт цаасыг бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтаас бүрмөсөн хасна. Үүнд:
- 59.1 “Компанийн тухай хууль”-ийн 18; 26 дугаар зүйлд заасны дагуу компанийг өөрчлөн зохион байгуулах, татан буулгах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр гарсан;

- 59.2 Бүртгэлтэй өрийн бичгийн үндсэн болон хүүгийн төлбөр бүрэн төлөгдсөн;
- 59.3 Бүртгэлтэй үнэт цаас гаргагчийн жагсаалтаас түр хасагдаж, журмын 14-д заасан хугацаанд дахин бүртгүүлэх хүсэлт гаргаагүй;
60. Дараах тохиолдолд үнэт цаасыг Гүйцэтгэх захирлын шийдвэрээр бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтаас түр хасч бүртгэлтэй компанийн жагсаалтад бүртгэнэ. Үүнд:
- 60.1 Дараах нөхцлүүдийн 2 хүртлэх зүйлийг хангахгүй болсон хувьцаа:
- Бүртгэлийн шалгуур үзүүлэлтийг хангахгүй болсон;
 - Зах зээл дээр мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам заавар, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт хангалтгүй;
 - Үнэт цаас гаргагчаас олон нийтэд хүргэх шаардлагатай мэдээллийг хүргээгүй буюу нуун дарагдуулсан нь тогтоогдсон;
 - Үнэт цаас нь сүүлийн 1 жилд огт арилжигдаагүй;
- 60.2 Үндсэн болон хүүгийн төлбөр нь хугацаандаа бүрэн төлөгдөөгүй өрийн бичгийн үлдэгдэл.
61. Үнэт цаас гаргагч нь үнэт цаасаа бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтаас бүрмөсөн хасуулахад дараах баримт бичгийг бүрдүүлэн ирүүлнэ. Үүнд:
- 61.1 Үнэт цаас бүртгэлээс хасуулах тухай хүсэлт;
 - 61.2 Үнэт цаас бүртгэлээс хасахтай холбоотой эрх бүхий этгээдийн шийдвэр;
 - 61.3 Хувь нийлүүлэгчдийн хурлын зар, хурлын тэмдэглэл;
 - 61.4 Компанийг өөрчлөн зохион байгуулах бол өөрчлөн зохион байгуулах төсөл / төсөлд компанийг өөрчлөн зохион байгуулах шалтгаан, зорилго, хувьцааг хөрвүүлэх арга, тооцоог тусгасан байна/;
 - 61.5 Компанийг өөрчлөн зохион байгуулах асуудлаар эсрэг саналтай байсан буюу хуралд оролцоогүй хувьцаа эзэмшигчдийн компанид хувьцаагаа эргүүлэн худалдан авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх журам, түүнийг баталж, мөрдөх тухай шийдвэр;
 - 61.6 Хувьцаа эргүүлэн худалдан авах үнийг тогтоосон тухай үнэлгээний байгууллагын дүгнэлт;
 - 61.7 Компанийг татан буулгаж байгаа бол татан буулгах комисс байгуулсан тухай эрх бүхий этгээдийн шийдвэр;
 - 61.8 Компанийг татан буулгасны дараа нэхэмжлэл гаргах журам, үлдэгдэл эд хөрөнгийг хувь нийлүүлэгчдэд хуваарилах журам;
 - 61.9 Өөрчлөн зохион байгуулагдах болон татан буугдах үеийн дуусгалтын тайлан баланс;
 - 61.10 Бүртгэлтэй компанийн жилийн хураамжийн өртэй тохиолдолд хураамж төлсөн баримт;
 - 61.11 Өрийн бичиг гаргагчийн хувьд үндсэн болон хүүгийн төлбөр төлөлтийн таалархи ҮЦТТХТ-ийн тодорхойлолт
 - 61.12 Бусад

62. МХБ нь үнэт цаас эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор үнэт цаасны бүртгэлээс хасах шалгалтыг хийнэ.
63. Шалгалтыг үнэт цаасны бүртгэл хариуцсан мэрэгжилтэн үнэт цаас гаргагчаас баримт материалыг бүрэн хүлээн авснаас хойш ажлын 10 хоногийн дотор хийж дуусгана.
64. Үнэт цаас бүртгэлээс хасах шалгалтын тайлан, дүгнэлтийг ЗЗХ-аар хэлэлцэн, үнэт цаасыг МХБ-ийн бүртгэлээс бүр мөсөн хасах, бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтаас түр хасч бүртгэлтэй компанийн жагсаалтад бүртгэх эсэх тухай шийдвэрийг Гүйцэтгэх захирал гаргана.
65. МХБ-ийн зүгээс үнэт цаас гаргагчийг шаардлагатай баримт материалыг дутуу бүрдүүлсэн буюу хууль, журмаар хүлээсэн үүргийн хэрэгжилтийг бүрэн хангаагүй гэж үзсэн тохиолдолд бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтаас түр хасч, шаардлагыг биелүүлж, хэрэгжилтийг бүрэн хангах хүртэл хугацаагаар бүртгэлтэй компанийн жагсаалтад бүртгэнэ.

Ес. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИД ТАВИХ ХЯНАЛТ

66. Үнэт цаас гаргагчид тавих хяналтыг дараах төрлийн шалгалтаар хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 66.1 Элсэлтийн шалгалт;
 - 66.2 Бүртгэлийн шалгалт;
 - 66.3 Тогтмол шалгалт;
 - 66.4 Тусгай шалгалт;
67. Элсэлтийн шалгалтыг үнэт цаас гаргагчийг МХБ-д бүртгэн авахад, бүртгэлийн шалгалтыг үнэт цаас гаргагчаас үнэт цаас бүртгүүлэх хүсэлт гаргасан тохиолдолд хийнэ.
68. Тогтмол шалгалтыг бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтанд бүртгэгдсэн үнэт цаас гаргагчид журмын 4 дүгээр бүлгийн шалгуур үзүүлэлтийг хангаж буй эсэх, 5 дугаар бүлгээр тавигдсан шаардлагын биелэлтийн байдалд хяналт тавих зорилгоор тогтмол судалгаа хөтөлж, шаардлага хүргүүлэх замаар хэрэгжүүлнэ.
69. Тусгай шалгалтыг бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтанд бүртгэгдсэн үнэт цаас гаргагчийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэлд гарсан болон хөрөнгө оруулагч, иргэд, бусад байгууллагаас ирсэн мэдээлэл, өргөдөл, гомдолд үндэслэн МХБ-ийн удирдлагын зүгээс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд хийнэ.
70. Бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтанд бүртгэгдсэн үнэт цаас гаргагчийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд тараагдсан мэдээлэл нь хувьцаа эзэмшигч, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг зөрчиж болзошгүй гэж үзсэн тохиолдолд МХБ нь тухайн үнэт цаас гаргагчийг уг мэдээллийн талаар олон нийтэд тайлбар хийхийг шаардах эрхтэй.

Арав. ХУРААМЖ

71. Үнэт цаас гаргагч нь МХБ-д хувьцаа бүртгүүлэхэд дараах хураамжийг төлнө.
Үүнд:
- 71.1. Үнэт цаасны элсэлтийн хураамж
 - 71.2. Бүртгэлтэй компанийн жилийн хураамж
- /ТУЗ-ийн 2012.02.17-ны өдрийн 05 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан/*
- 72 Үнэт цаасны элсэлтийн хураамжийг үнэт цаас гаргагчийг МХБ-д бүртгэхэд зөвхөн нэг удаа тус компанийн зах зээлийн үнэлгээний 0.1 хувиар тооцон авна. Үнэт цаасны элсэлтийн хураамжийн доод хязгаар нь 12,000,000 /арван хоёр сая/ төгрөг ба дээд хязгаар нь 240,000,000 /хоёр зуун дөчин сая/ төгрөг байна. */ТУЗ-ийн 2012.02.17-ны өдрийн 05 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан/*
- 73 Бүртгэлтэй компанийн жилийн хураамжийг үнэт цаас гаргагчийн зах зээлийн үнэлгээний 0.005%-иар тооцоон жил бүр авна. Зах зээлийн үнэлгээг тооцохдоо тухайн жилийн хамгийн сүүлийн арилжааны өдрийн хаалтын ханшаар тооцох ба жилийн хураамжийн доод хязгаар нь 1,200,000 /нэг сая хоёр зуун мянга/ төгрөг ба дээд хязгаар нь 24,000,000 /хорин дөрвөн сая/ төгрөг байна. */ТУЗ-ийн 2012.02.17-ны өдрийн 05 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан/*
- 74 Үнэт цаас гаргагч нь нэмж болон өрийг хувьцаагаар солиход гаргасан хувьцааг бүртгүүлэхэд журмын 72-д заасан хувь хэмжээгээр үнэт цаасны элсэлтийн хураамж төлнө.
- 75 Үнэт цаас гаргагч нь МХБ-д бүртгүүлэх хүсэлтийг үнэт цаас бүртгүүлэх хүсэлтэй зэрэг гаргасан тохолдолд тухайн жилийн бүртгэлтэй компанийн жилийн хураамжаас чөлөөлөгдөнө.
- 76 Бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтаас түр хасагдаж бүртгэлтэй компанийн жагсаалтанд бүртгэгдсэн үнэт цаас гаргагч нь журмын 14-д заасан хугацаанд журмын 73-д заасан бүртгэлтэй компанийн жилийн хураамжийг төлнө.
- 77 Үнэт цаас гаргагч нь бүртгэлтэй компанийн жилийн хураамжийг тухайн жилийн эхний улиралд багтаан төлнө. */ТУЗ-ийн 2012.02.17-ны өдрийн 05 тоот тогтоолоор нэмэлт өөрчлөлт оруулсан/*
- 78 Үнэт цаас гаргагч нь өрийн бичиг бүртгүүлэхэд зөвхөн бүртгэлтэй компанийн жилийн хураамж төлөх бөгөөд түүнийг анхдагч зах зээл дээр арилжигдсан үнийн дүнгээс тооцож авна.
- 79 Бүртгэлтэй компанийн жилийн хураамж нь Засгийн газар, орон нутгийн гаргасан өрийн бичгийн арилжигдсан үнийн дүнгийн 0.05 хувь, компанийн гаргасан өрийн бичгийн арилжигдсан үнийн дүнгийн 0.1 хувьтай тэнцүү байна.

Арван нэг. ХАРИУЦЛАГА

- 80 Бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтад бүртгэгдсэн үнэт цаас гаргагч нь “Компанийн тухай”, “Үнэт цаасны зах зээлийн тухай” хуулиуд болон "Үнэт цаас гаргагчтай байгуулсан гэрээ"-гээр хүлээсэн үүргийг биелүүлээгүй нь тогтмол шалгалтын явцад тогтоогдсон бол МХБ-ээс тухайн үнэт цаас гаргагч болон гэрээ байгуулсан андеррайтерт албан бичгээр мэдэгдэл хүргүүлнэ.
- 81 Үнэт цаас гаргагч нь уг мэдэгдлийг хүлээн авснаас хойш Улаанбаатар хотод ажлын 15, орон нутагт ажлын 30 хоногийн дотор зөрчлийг арилгаж, хариу мэдэгдэнэ.
- 82 Журмын 81-д заасан хугацаанд холбогдох хууль, журам, гэрээгээр хүлээсэн үүргийг биелүүлээгүй бол Гүйцэтгэх захирлын тушаалаар тухайн үнэт цаас гаргагчийн үнэт цаасны арилжааг түр хугацаагаар зогсоож, олон нийтэд мэдээлнэ.
- 83 Үнэт цаас гаргагч нь арилжаа зогсоосноос хойш 2 сарын дотор үүргээ биелүүлээгүй нь түүнийг бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтаас түр хасаж, бүртгэлтэй компанийн жагсаалтанд бүртгэх үндэслэл болох бөгөөд энэ тухай олон нийтэд мэдээлнэ.
- 84 Бүртгэлтэй үнэт цаасны жагсаалтаас түр хасагдаж, бүртгэлтэй компанийн жагсаалтанд бүртгэгдсэн үнэт цаас гаргагч нь журмын 14-д заасан хугацаанд 5 дугаар бүлэгт заасан шаардлагыг хэрэгжүүлнэ.
- 85 Компанийн болон үнэт цаасны бүртгэл хариуцсан мэрэгжилтэн нь холбогдох шалгалт, түүний тайлан, дүгнэлтийг заасан хугацаанд бүрэн бэлтгэж, удирдлагад танилцуулах ба журмын заалтыг зөрчсөн тохиолдолд Монгол улсын холбогдох хууль тогтоомж, МХБ-ийн журам, заавар, хөдөлмөрийн гэрээний дагуу арга хэмжээ авна.

ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

/Хувьцаа/

1. Үнэт цаас гаргагчийн нэр:
2. Хаяг:
3. Улсын бүртгэлийн дугаар:
4. Компанийн үйл ажиллагааны талаарх товч танилцуулга:
5. Дүрмийн сангийн хэмжээ:
6. Бүртгүүлэх үнэт цаасны төрөл:
7. Бүртгүүлэх үнэт цаасны тоо:
 - 1/ Үнэт цаасны тоо
 - 2/ Нэрлэсэн үнэ
 - 3/ Үнийн дүн
8. Үнэт цаасыг санал болгох хүрээ:
9. Цөөнхөд санал болгох тохиолдолд:

Захиалагч	Тоо ширхэг	Үнэ
-----------	------------	-----

10. Удирдлагын тухайн компанийн хувьцаа эзэмшиж буй байдал

Нэр	Хаяг	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны тоо	Хувь
-----	------	--------------	---------------------------	------

Өргөдлийг үнэн зөв гаргасан:

ТУЗ-ийн дарга	/ гарын үсэг /
---------------	----------------

Тамга

Гүйцэтгэх захирал	/ гарын үсэг /
-------------------	----------------

20 он сар өдөр

Өргөдөл хүлээн авсан:

Албаны ажилтан:	/ гарын үсэг /
-----------------	----------------

ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

/Засгийн газрын бонд/

1. Үнэт цаас гаргагчийн нэр:
2. Үнэт цаас гаргах зорилго:
3. Үнэт цаасны санал болгох хүрээ:
4. Үнэт цаасны төрөл:
5. Нэрлэсэн үнэ / төгрөг /:
6. Нийт гаргах тоо:
7. Нийт үнийн дүн:
8. Гаргах хугацаа, тоо хэмжээ, хямдруулсан үнэ:
9. Үнэт цаас гаргах эрх бүхий байгууллагын шийдвэр:
10. Баталгаа:

Өргөдлийг үнэн зөв гаргасан:

Санхүү, эдийн засгийн яамны

Төрийн сангийн газрын дарга

/ гарын үсэг /

Тамга

20 он сар өдөр

Өргөдөл хүлээн авсан:

МХБ-ийн БА-ны захирал:

/ гарын үсэг /

Бүртгэн авахыг зөвшөөрсөн:

МХБ-ийн гүйцэтгэх захирал

/ гарын үсэг /

20 он сар өдөр

ҮНЭТ ЦААС БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

/компанийн бонд/

1. Үнэт цаас гаргагчийн нэр:
2. Хаяг:
3. Улсын бүртгэлийн дугаар:
4. Компанийн үйл ажиллагааны талаарх товч танилцуулга:
5. Дүрмийн сангийн хэмжээ:
6. Бүртгүүлэх үнэт цаасны төрөл:
7. Бүртгүүлэх үнэт цаасны тоо:

1/ Үнэт цаасны тоо

2/ Нэрлэсэн үнэ

3/ Үнийн дүн

4/ Үнэт цаасны сарын хүү

5/ Буцаан төлөгдөх хугацаа

8. Удирдлагын хувьцаа эзэмшиж буй байдал

Нэр	Хаяг	Албан тушаал	Эзэмшиж буй хувьцааны тоо	Хувь
-----	------	--------------	---------------------------	------

Өргөдлийг үнэн зөв гаргасан:

ТУЗ-ийн дарга	/ гарын үсэг /
---------------	----------------

Тамга

Гүйцэтгэх захирал	/ гарын үсэг /
-------------------	----------------

20 он сар өдөр

Өргөдөл хүлээн авсан:

Албаны ажилтан:	/ гарын үсэг /
-----------------	----------------

20 он сар өдөр